

## **МОНГОЛЫН ХҮН АМ ЗҮЙН ЦОНХ, ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨ**

**3. Цолмонбаяр, ажилтан,  
Хүн ам ба Тогтвортой  
Хөгжлийг дэмжих Олон нийтийн  
Хамтын ажиллагааны Төв**

*Хөгжсиж буй улс орнуудын нэгэн адил Монгол улсын хүн ам залуу наасны бүтэцтэй. Гэсэн хэдий хүн ам наасны бүтэц төрөлтийн огцом бууралттай уялдан хурдан өөрчлөгдөж байна. Насны бүтцийн энэхүү өөрчлөлт нь Монголын эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх боломжтой хүн ам зүйн таатай орчинг бүрэлдүүлээд байна.*

*Хүн ам зүйн ачаалал буурснаар өрхийн орлого болон хэрэглээний бүтцэд онцгой өөрчлөлтүүд гарч байна. Хүн амын худалдан авах чадварын өсөлтийг эдийн засгийн сонгодог онолын ууднээс харвал энэхүү өсөлт нь бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж, улмаар эрэлтийн өсөлтийг дагаад нийлүүлэлт ч нэмэгдэн эдийн засгийн өсөлт бий болох болно.*

*Хүн ам зүйн цонхны бас нэг ашигтай тал нь нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэх боломж бөгөөд орлого нэмэгдсэнээр хүмүүс илүү чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх чадвартай болж хүний хөгжлийн асуудалд эерэг нөлөө үзүүлэх юм.*

*Эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх Монголын хүн ам зүйн энэхүү таатай орчин 2030 оны дунд үеэс төгсгөл болох төлөвлөтэй тул энэ боломжийг ашиглан хүний нөөцийн ашиглалтын чиглэлээр эдийн засгийн хүчтэй бодлого явуулах зайлигүй шаардлагатай байна.*

### **1. Удиртгал**

ХХ зууны хоёрдугаар хагас нь Монголын төдийгүй дэлхийн бусад улс, гүрнүүдийн улс төр, эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн орчинд огцом өөрчлөлтүүд тохиосон үе байсан гэдэгтэй та бүхэн санал нэгдэх байхаа. Дэлхийн 2-р дайны дараа олон улсын харилцааны системд олон талт болон хоёр талт энх тайванч харилцааг эрхэмлэх нь түлхүү болсноор улс орнууд өөрсдийн эдийн засаг, нийгмийн амьдралаа тайван замаар хөгжүүлэх боломжтой болсон юм. Энэ үед улс орнууд ногоон хувьсгалын аяныг хэрэгжүүлж, халдварт өвчний эсрэг вакцинуудыг нээн илрүүлсэн нь төрөлт нэмэгдэх, нас баралт буурах, ялангуяа эх, нялхсын эндэгдэл буурах үндсэн шалтгаан болжээ. Энэхүү өөрчлөлтийн үр нөлөөгөөр дэлхийн хүн ам огцом өсөв.


АНУ-н Тооллогын товчооны дэлхийн хүн амын өсөлтийн талаар гаргасан илтгэлд дурдсанаар 1900-1950 оны хооронд дэлхийн хүн амын жилийн дундаж өсөлт 0.9 хувьтай байсан бол 1950-2000 оны хооронд 1.3 хувь болж өссөн байна. Энэхүү өсөлтийн үр дүнд 1950 онд 2.6 тэрбум байсан дэлхийн хүн ам 2000 онд 6.1

тэрбумд хүрч 3.5 тэрбуулаар өсчээ. Өөрөөр хэлвэл, сүүлийн 1950-2000 оны хооронд хүн амын тоо нэмэгдсэн нь өнгөрсөн 2 мянган жилийн хүн амын тооноос давж гарсан нь харагдаж байна. Дэлхийн хүн амын өсөлтийн энэхүү чиг хандлага Ази тивийн хүн амын өсөлтөд ч мөн ажиглагдаж байна.

ХХ зууны эхний хагаст Азийн хүн амын жилийн дундаж өсөлт 0.8 хувь байсан бол хоёрдугаар хагаст 1.9 хувь болж 2 дахин өсчээ. Тодруулбал, Ази тивийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг дэлхийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдтай харьцуулахад, 1950-аад оныг хүртэл өсөлтийн хурдаараа бага байсан Азийн хүн ам ХХ зууны сүүлийн хагаст гүйцэж түрүүлэн хол хаяжээ гэсэн үг.

Ази тивийн зүрхэнд байрлах Монгол Улсын хувьд хүн амын тоо 1900-1950 оны хооронд жилд дунджаар 0.3 хувиар өсөж байсан ч 1950-2000 оны хооронд 2.3 хувиар өсөх болсон нь Азийн хүн амын өсөлтийн хурдаас ч давж гарав. Энэхүү өөрчлөлтийн талаар товч тайлбар өгөх нь зүйтэй болов уу.

*Зураг 1. Монголын хүн ам зүйн шилжилт*



Хүн ам зүйн шилжилтийн үеүүдийг харуулсан дээрх зургаас Монголын хүн ам зүйн түүхэн чиг хандлага нь Ази болон Дэлхийн бусад орнуудынхаас ялгаатай байгааг харж болно. Монголын хүн ам зүйн шилжилтийн эхний үе 1950-аад оныг хүртэл үргэлжилсэн бөгөөд энэ үед төрөлт, нас баралтын түвшингийн аль аль нь доогуур, зарим онуудад нас баралт нь төрөлт, нас баралтын түвшингийн загвараас харахад эхний үед төрөлт, нас баралт хоёулаа өндөр түвшинтэй байдаг. 1900-аас 1918 он хүртэл Монголын хүн ам 0.1 хувиар өссөн байдаг. Энэ талаар «Монгол Улсын хүн ам 20-р зуунд» эмхтгэлийн оршил хэсэгт «... 1921 оныг хүртэл Монголд нас баралт, ялангуяа нялхсын нас баралт маш өндөр байсан нь нийгэм, эдийн засгийн хөгжил дорой, орчин үеийн эрүүл мэндийн систем бий болоогүй байсантай холбоотой юм. Баримтаас үзэхэд, шинээр төрсөн хүүхдүүдийн тал хувь нь нэг хүртэл насандаа, төрсөн эхчүүдийн 13.2 хувь нь төрөх үедээ энддэг байсан...» гэж товч дурдсан байна.

1950-аад оны дунд үеэс хүн ам зүйн шилжилтийн 2-р үе эхэлж 1980-аад оны сүүлээр дуусчээ. Хүн ам зүйн шилжилтийн онолоор нас баралтын огцом бууралт, төрөлтийн тогтвортой төлвийг 2-р үеийн үндсэн шинж гэж үздэг. Гэтэл

Монголын хувьд 1950-1980 оны хооронд төрөлт огцом өссөн, нас баралт бага зэрэг буурсан хандлагатай байгаа нь коммунизмын төлөөх түншлэгчдийн нэг хуучин ЗХУ-ын дэмжлэгтэйгээр бүх нийтийг эрүүлжүүлэх ажлыг үнэ төлбөргүй хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж болох юм. Энэ тухай дээр дурдсан эмхтгэлд «...Хүн амын дунд нас баралтын голлох шалтгаан болоод байсан “улаан эсэргэнэ” гэх мэт халдварт өвчинүүдийн эсрэг вакцинуулалтын ажлыг 1934, 1935 онуудад хийсэн. Мөн 1925 онд хоёрхон их эмч байсан бол 1935 онд 60 их эмчтэй болж, 12.3 мянган хүнд 1 их эмч ногдох болжээ. Мөн сүрьеэгийн эсрэг бүх нийтийг хамарсан вакцинуулалтыг 1950-60 оны хооронд 2 удаа явуулсан. Энэ бүх ажилд нийт хүн амын 82.9-95.8 хувь хамрагдсан байна. 1963 оны байдлаар 1216 их эмчтэй болсон нь 10000 хүнд 11.6 их эмч ногдож байсныг харуулна» гэж бичжээ. 1937-1945 оны хооронд өрнөсөн том, жижиг дайнууд төгсгөл болж, тусгаар тогтолцоо баталгаажуулснаас хойш манай улс эдийн засаг, нийгмийн амьдралаа хөгжүүлэхэд илүү боломж бүрдсэн юм.

Тухайн үед боловсрол, эрүүл мэнд гэх мэт нийгмийн хalamжийн суурь үйлчилгээнүүдийг төлбөргүй болгож, хүн бүрийг ажлын байраар хангах үүргийг төр өөр дээрээ үүрч байв. Энэ бодлогын үр дүнгээр 1970-80-аад оны үед манай улсад «төрөлтийн тэсрэлт» болж, сүүлийн 50 жилийн хугацаанд хүн амын тоо 3 дахин өсөн 2.4 саяд хүрсэн юм. 1970-1980 он нь Монгол улсын хүн өсөлтийн хамгийн оргил үе байсан бөгөөд жилийн дундаж өсөлт 2.7 хувь, төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) 6.4-т тус тус хүрч байжээ. Зарим бүс нутгуудад төрөлтийн нийлбэр коэффициент 8-аас давж гарсан байдаг. Энэ бүхний үр дүнд манай улсын хүн амын насны бүтэц залуужсан юм.

1990-ээд оны эхээр манай улсын улс төр, эдийн засгийн харилцаа үндсээрээ өөрчлөгдөж, зах зээлийн чиг баримжаатай болсонтой холбоотойгоор төр засаг өөртөө үүрээд байсан зарим ачаагаа өрх гэрүүдэд үүрүүлэв. Улс орны дотоодод гарсан энэ өөрчлөлтийн нөлөөгөөр ажилгүйдэл, ядуурал гэсэн ойлголтууд шинээр төрж, хүн амын дунд өндөр хувь эзэлдэг боллоо. Үүгээр ч зогсохгүй эрүүл мэндийн үйлчилгээ төлбөртэй болсон нь хүмүүсийн төрөлтөд хандах хандлагыг өөрчилсөн гэдгийг 1990 онд 4.5 байсан ТНК арван жилийн дараа 2.2 болон буурснаар тайлбарлаж болох юм. Төрөлт огцом буурсан 1990-ээд оныг Монголын хүн ам зүйн шилжилтийн 3-р үе гэж үзвэл энэ нь Хүн ам зүйн шилжилтийн онолд дурдсантай тохирч байгаа юм. Ийнхүү төрөлт огцом буурснаар хүн амын насны бүтэц хөгшрөх хандлагатай болон хувирч байна.


Энэхүү насны бүтцийн өөрчлөлт нь дараагийн 35 жилийн хугацаанд Монголын эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх боломжтой хүн ам зүйн орчны тааламжтай уур амьсгал бүрдээд буйг илтгэнэ. Монгол улс 20-р зуунд хүн амаа 9 удаа тоолсоны отгон нь 2000 онд хийгдсэн билээ. Монголын хүн ам зүйн орчны талаар судалгаа хийхэд дээрх тооллогуудын үр дүн үнэтэй мэдээлүүдийг өгч байсныг энд зайлшигүй дурдах хэрэгтэй. Эдгээр тооллогуудын үр дүнгээс гадна сүүлчийн тооллогын дүнд үндэслэсэн 2025 он хүртэлх хэтийн тооцоог судалгаандаа ашиглав. Гэхдээ хэтийн тооцооны дээд, дунд, доод гэсэн 3 хувилбараас үндсэн чиг хандлагыг илэрхийлснээр нь дунд хувилбарын тооцоог дангаар нь ашигласан болно.

## 2. Насны бүтцийн өөрчлөлт ба «хүн ам зүйн цонх»

Монгол улсын хүн ам хөгжиж буй бусад орнуудын нэгэн адил залуу насны бүтэцтэйд тооцогддог. 2000 онд голч нас буюу хүн амын тоог тэнцүү хэсэгт хуваагч нас 21.6 байсан нь үүний нотолгоо болох биз. Хүн амын хэтийн

тооцооны хамрах хугацааны эцэст голч нас 32.5 болохоор тооцогдсон нь насны бүтэц ямар хэмжээгээр өөрчлөгдөх гэж буйг дохиолж байна.

### Зураг 2. Хүн амын нас – хүйсийн сувадга




Насны бүтэц өөрчлөгдөхөд хүн ам зүйн ачаалал дагаад өөрчлөгдеж байдаг. Одоогийн манай улсын хүн амын насны бүтцийн өөрчлөлтийн дунд хүн ам зүйн ачаалал буурч, ингэснээр өрхүүдийн худалдан авах чадвар сайжрах, орлого нь хэрэглээгээ бүрэн хангаад, цаана нь нөөцлөх мөнгө үлдэх, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж бүрдлээ. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн тоо буюу тэжээлгэгчдийн тоо буурснаар нэг хүнд ногдох орлогын хэмжээг өснэ. Нэг хүнд ногдох орлого өссөнөөр өрхүүд мөнгөө хуримтлуулах, эсвэл хувь хүний сонирхлоос хамаараад тодорхой төрлийн хэрэглээгээ нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэсэн үг. Үүнийг л бид «хүн ам зүйн цонх» гэж нэрлэж байна. Хүн ам зүйн ачааллыг тооцох аргачлалын хувьд өнөөдөр манайд олон улсын нийтлэг жишигийн дагуу хөдөлмөрийн нас гэдэгт 15-64 насныхныг, хүүхэд гэдэгт 14 хүртэл насныхныг, хөгшид гэдэгт 65-аас дээш насныхныг хамруулан тооцдог.

1956 онд хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчдийн тоо 57 байсан бөгөөд энэ үзүүлэлт 1963 онд 82, 1969 онд 101 болон огцом өсчээ. Харин үүнээс хойш буурсан бөгөөд 1979 онд 96, 1989 онд 84, 2000 онд 64 гэж тооцогдсон байна. Хүн амын хэтийн тооцооны дагуу уг үзүүлэлтийн бууралт цаашид үргэлжлэх бөгөөд 2005 онд 52, 2010 онд 46, 2020 онд 42, 2025 онд 41 болох төлөв ажиглагдаж байна. Хэтийн тооцооны хамарсан 25 жилийн дараагийн 10 жилд манай улсын хүн ам зүйн орчинд онцгой өөрчлөлт гарахаар хүлээгдэж байгааг эндээс харж болно. Учир нь 1970-80-аад оны «төрөлтийн тэсрэлт» болж байх үсийн төрөлтүүд тухайн үед тэжээлгэгчийн насанд хүрээд, харин төрөлт буурч байгаа өнөөдрийн төрөлтүүд тэр үед хөдөлмөрийн насанд хүрэх болно. Үүний үр дунд хүн ам зүйн ачаалал гэсэн үзүүлэлт маань өсч, өрхийн түвшинд хэрэглээ бүрэн хангахгүй, хөрөнгө мөнгөний асуудлыг бий болгох талтай. Тиймээс би тодорхой баримт дээр тулгуурлан Монголын хүн ам зүйн цонх эдийн засгийн хөгжилдөө ямар нөлөө үзүүлж болохыг судлахаар шийдлээ.

Юуны өмнө тэжээлгэгч хүүхэд, хөгшдийн аль нь хөдөлмөрийн насныханд илүү дарамт үзүүлээд байгааг сонирхоё.

**Зураг 3. Насны бүтцийн шилжилт, 1969-2025**




Төрөлтийн огцом өсөлт явагдсан учир 0-14 насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь 1956 онд 30.4 хувь байснаа 1963 он хүртэлх 7 жилийн дотор 8.6 пунктээр, 1963-69 он хүртэлх 6 жилийн хугацаанд 5.4 пунктээр өсчээ. Гэвч 0-14 насныхны хувийн жин 1969-79 оны хооронд 0.2 пунктээр, 1979-89 оны хооронд 2.4 пунктээр буурч байсан нь төрөлтийн түвшин аажим буурч байсныг харуулна. Харин 1989-2000 оны хооронд уг хувийн жин 6.4 пунктээр буурсан нь сүүлийн жилүүдийн төрөлтийн огцом бууралттай холбоотой юм. Хүн амын хэтийн тооцоогоор 0-14 насны хүн амын хувийн жин цаашдаа ч буурах хандлагатай гарсан. Тухайлбал, 2010 онд нийт хүн амын 27.5 хувь, 2020 онд 24.7 хувь, 2025 онд 22.8 хувийг 0-14 насны хүн ам эзлэх төлөвтэй байна.

65-аас дээш насны ахмадуудын хувьд 1956 онд нийт хүн амын 6.2 хувийг эзэлж байгаад 1963 онд 6.3 хувь эзлэх болж хувийн жин нь бага зэрэг нэмэгдсэн. Харин үүнээс хойш байнга буурч ирснийг харвал, 1969 онд 6.0 хувь, 1979 онд 5.0 хувь, 1989 онд 4.0 хувь, 2000 онд 3.4 хувийг эзэлж байжээ. Хэтийн тооцооны дүнгээр 2005 онд нийт хүн амд ахмадуудын эзлэх хувь 3.6 хувь болон нэмэгдэх бөгөөд энэ өсөлт нь цаашдаа ч хадгалагдаж, 2025 он гэхэд одоогийнхоосоо бараг 2 дахин нэмэгдэж, 6.3 хувьд хүрэхээр байна.

Эндээс харахад хөдөлмөрийн насны хүн амд үзүүлж байгаа хүүхдийн ачаалал ахмадуудынхаас өндөр байгаа юм.

**Зураг 4. Хүн ам зүйн ачаалал, бүс нутгаар, 2000-2025**



Бүсүүдийн хувьд улсын дундажтай нэгэн адил хүн ам зүйн ачаалал буурч буй учир эдийн засгаа өсгөхөд таатай нөхцөл бүрдээд байна. Бүсүүд дотроос

хамгийн бага хүн ам зүйн ачаалалтай нь нийслэл хот бөгөөд 2000 онд 50.3 байсан хүн ам зүйн ачаалал 2010 онд 40.4, 2025 онд 37.4 болон буурах хандлагатай байна. Өөрөөр хэлвэл, бусад бүсүүдээсээ илүүтэйгээр Улаанбаатар хотод эдийн засгийн өсөлтөд таатай нөхцөл бүрдсэн ажээ. Үүний цаад шалтгаан нь дотоод шилжих хөдөлгөөн буюу хөдөө, орон нутгаас хөдөлмөрлөх чадвартай хөдөлмөрийн насны залуучууд нь Улаанбаатар хот руу түлхүү шилжсэн явдал юм. Хэтийн тооцоонд хамруулсан хугацаанд бүх бүсүүд ижил таатай нөхцөлгүй байгаагийн өөр нэгэн жишээ бол Зүүн бүс бөгөөд тус бүсийн хүн ам зүйн ачаалал 2020-2025 онд 0.4 пунктээр өсөх төлөвтэй байна.

### **3. Хүн ам зүйн цонх ба эдийн засгийн өсөлт**

Хүн ам зүйн цонх эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх талаар авч үзье. Хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээгдэгчид буюу хүүхэд, хөгшдийн тоо буурснаар өрхийн түвшинд илүүдэл орлого бий болох эсвэл тэдний худалдан авах чадвар сайжрах замаар эдийн засгийн өсөлтөд эсрэг нөлөө үзүүлдэг тухай өмнө дурдсан билээ. Өөрөөр хэлбэл, өрхийн хэрэглээ нь тухайн өрхийн гишүүдийн тооноос хамаардгийг хүн бүр мэдэх бөгөөд хөдөлмөр эрхэлж орлого олох боломжтой хүн амын тоо болон орлого олох бололцоо багатай хүүхэд, хөгшдийн тооны харьцаа буурснаар өрхийн хэрэглээний хэмжээ буурах, ингэснээр орлогын илүүдэл нөөц бий болно гэсэн үг. Эс бөгөөс олсон орлогоо бүгдийг хэрэглэж болох бөгөөд энэ тохиолдолд өрхийн худалдан авах чадвар нэмэгдэнэ. Хэрэв бид худалдан авах чадварын өсөлтийг эдийн засгийн сонгодог онолын үүдиэс харвал энэ өсөлт нь бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж, улмаар эрэлтийн өсөлтийг дагаад нийлүүлэлт ч нэмэгдэн эдийн засгийн өсөлт бий болох ёстой гэсэн дүгнэлтэд хүрнэ. Нөгөө талаас өрх гэрүүд илүүдэл орлогоо хуримтлуулж болох бөгөөд энэхүү хуримтлал нь санхүүгийн зуучлагч байгууллагуудын тусламжтайгаар хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр болон хувирах боломжтой.

Хүн ам зүйн цонхны өөр нэгэн ашигтай тал бол нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэх боломж бөгөөд орлого нэмэгдсэнээр хүмүүс илүү чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх чадвартай болох юм. Өөрөөр хэлбэл хүн ам зүйн цонх эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлээд зогсохгүй хүний хөгжилд ч эсрэг нөлөө үзүүлдэг ажээ. Гэсэн хэдий ч хүн ам зүйн цонх болон эдийн засгийн өсөлтийн харилцан холбоо нь бусад олон хүчин зүйлсийн нөлөөллөөс хамаарч тодорхой бус байна. Үүнийг тодорхой болгохын тулд тухайн улсын хүн амын шинжүүдийг тодорхойлох хэрэгтэй.


### **4. Хүн амын бусад үзүүлэлтүүд ба эдийн засгийн өсөлт**

Энд хүний хөгжлийн үзүүлэлтүүд голлон яригдах бөгөөд хүн амын насны бүтцээс бусад үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлдөг талаар авч үзэх юм. Юуны өмнө хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох боловсрол, эрүүл мэндийн талаар ярья.

Монголын хүн ам, хөгжиж буй бусад орнуудын хүн амыг бодвол өндөр боловсролтойд тооцогддог. 2000 оны тооллогын дүнгээр 8-аас дээш настай хүн амын 97.1 хувь нь бичиг үсэгт тайлгадсан гэж гарсан нь хүний хөгжлийн хувьд сайн үзүүлэлт. Ялангуяа 20-оос дээш настай хүн амын дөрөвний нэгээс илүү нь техник мэргэжлийнхээс дээш түвшний боловсролтой байна. Эндээс манай улсад үйлдвэрлэлийн өргөжилтийг бий болгож чадах шинэ техник технологийг эзэмших чадвартай хүний нөөц байна гэдгийг харж болохоор байна. Энэ тохиолдолд бид зөвхөн боловсролын чанарын талаар л анхаарах хэрэгтэй юм.

Хүн амын дундаж наслалтын хувьд 1995-2000 онд эрэгтэйчүүдийнх 59.9, эмэгтэйчүүдийнх 63.9 байсан бөгөөд 25 жилийн дараа эрэгтэйчүүдийн дундаж наслалт 70, эмэгтэйчүүдийнх 74 хүрэх төлөвтэй байна. Дундаж наслалт нэмэгдэх нь эрүүл мэндийн тогтолцоо сайн хөгжиж байгааг харуулах боловч хувь хүний нас уртассанаар нийгмийн даатгалын сангаас гарах тэтгэвэр тэтгэмжийн зардлыг нэмэгдүүлнэ. θнөөдөр Баруун Европ, Япон, Хонконг, Сингапур зэрэг олон улс оронд энэ асуудал тулгамдаад байгаа бөгөөд зарим нь тэтгэврийн насыг шинэчлэн тогтоо замаар шийдэж байна.

### Зураг 5. Хүн амын хэт төвлөрөл, 2000



Боловсрол, эрүүл мэндээс гадна шилжих хөдөлгөөн эерэг, сөрөг хоёр хэлбэрээр эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байна. Монгол улс нь өргөн уудам газар нутаг, цөөхөн хүн амтайгаараа дэлхийд ганц орон юм. θнөөдрийн байдлаар дотоод шилжих хөдөлгөөний хөдөөнөөс хот руу гэсэн үндсэн урсгалын нөлөөгөөр нийт хүн амын гуравны нэг нь нийслэл хотдоо амьдрах болж хэт төвлөрөл явагджээ. Хот хөдөөгийн тэнцвэрийг хангасан эдийн засгийн бодлого явуулахгүйгээр энэхүү урсгалын чиглэл, далайцыг өөрчлөх боломж харагдахгүй л байна.

Гадаад шилжих хөдөлгөөний хувьд үндсэн чиглэл нь Япон, θмнөд Солонгос, АНУ, ХБНГУ гэх мэт хөгжингүй орнууд руу чиглэжээ. Гадаад шилжих хөдөлгөөн эрчимжсэнээр шилжигсдийг хүлээн авч буй болон гаргаж буй орны хооронд улс төр, эдийн засгийн харилцаа ойр дөт болох, шилжигсэд нь очсон орныхоо үр ашигтай туршлагуудыг эзэмших зэргээр эдийн засгийн өсөлтөд шууд бусаар нөлөөлдөг. Мөн шилжигсдийн эх орон руугаа гүйвуулж буй мөнгө нь эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлж байдаг. Тодруулбал, шилжигсдийн мөнгөн гүйвуулга нь микро түвшинд өрх гэрийн амьжиргааг сайжруулахаас гадна, макро түвшинд төлбөрийн тэнцилийн алдагдлыг бууруулах, санхүүгийн капитал болох зэргээр эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна. Мөнгөн гүйвуулгын хэмжээг Монгол банкнаас тооцсоныг харвал 2001 онд 25 сая ам.доллар байснаа 2002 онд 64.4 сая ам.доллар болон өсчээ. Энэ талаар Монголбанкны илтгэлд дурдаадаа «зарим судалгаанаас харахад банк хоорондын болон иргэдийн гүйвуулгын хэмжээ 2002 онд 100 сая ам.доллараар


давсан гэсэн үр дүн гарч байгаа нь ДНБ-ний 10 орчим хувьтай тэнцэж байна» гэжээ.

Өнөөдрийг хүртэл гадаад шилжих хөдөлгөөнд оролцогсдын нас, хүйс болон бусад үзүүлэлтийн талаар нарийвчилсан мэдээлэл алга байгаа нь харамсалтай.

## 5. Монголын «хүн ам зүйн цонх»-ны онцлог шинжүүд

Эхний онцлог нь хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхийр илрэн гарах ёстой. Хэрэв хөдөлмөрийн насны бүх хүн ам хөдөлмөр эрхэлж байвал хүн ам зүйн цонхын нөлөө хамгийн их байх болно. Хүн ам, орон сууцны 2000 оны тоологоор 15-64 насны хүн амын 53.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүн гарсан. Тодруулбал, хөдөлмөрийн насны хүн амын тал хувь нь хүүхэд, хөгшидийн нэгэн адил ачааллыг үүрч байна гэсэн үг юм.

**Зураг 6. Хүн амын эдийн засгийн идэвхи**



Тэдгээр хүн амын 44.3 хувь нь тодорхой шалтгааны (суралцах-25.5 хувь, өвчтэй тахир дутуу-5.4 хувь, тэтгэвэрт гарсан-13.4 хувь) улмаас ажил эрхлэхгүй байгаа бол 38.1 хувьд нь ажил хайгаад олдохгүй байгаа ажээ. Үлдсэн хэсэг нь гэрийн ажил болон бусад шалтгаанаар ажил эрхлээгүй байна.

Дараагийн онцлог нь ачаалал үзүүлж байгаа тэжээгдэгч хэсгийн бүтэц юм. Учир нь хөгшид, хүүхдүүд өөр өөр сонирхол, хэрэгшээтэй байдгаас хоорондоо ялгаатай ачааллыг бий болгож байдаг. Тухайлбал, хүүхдүүд боловсрол эзэмших хэрэгтэй учир боловсролд чиглэсэн зардлууд түлхүү гардаг бол хөгшидэд эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой зардлын хэрэгцээ өндөр байдаг. Нөгөө талаас ахмадууд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эсвэл хуримтлуулсан дадлага туршлагаа ашиглан ажил эрхэлж орлого олох замаар өөрсдийн хэрэгцээний зарим хэсгийг санхүүжүүлэх боломжтой байдаг бол хүүхдүүдэд орлого олох боломж хязгаарлагдмал байдаг. Монголын хувьд тэжээгдэгч хэсэг дотроо хүүхдүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь өрхийн хувьд хүнд ачаа болж байна. Харин ахмадуудын эзлэх хувь бага байгаа нь төрөөс үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний зардал харьцангуй бага байх үндэс болж байна. Гэвч ойрын ирээдүйд «төрөлтийн тэсрэлт»-ийн үед төрсөн хүмүүс тэжээгдэгч бүлэгт орж нийгмийн халамжийн сангийн зардлыг өсгөх болно. Гэтэл нийгмийн халамжийн сан нь тухайн үед ажил эрхлэж буй хүмүүсийн орлогоос бүрддэг тул засгийн газар уг өөрчлөлтөд бэлтгэлтэй байх хэрэгтэй.

## **6. Хүн ам зүйн цонх ба эдийн засгийн бодлогыг хэрхэн уялдуулах вэ?**

Дээрд дурдсан зүйлсээс харахад хүн ам зүйн цонх нээгдсэн боломжийг бүрэн гүйцэд ашиглахын тулд орлогын эх үүсвэрийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэг нь тодорхой юм. Үүнийг хэрэгжүүлэх арга замууд олон байж болох ч тэдгээр санаанууд нь Монголын улс төр, эдийн засгийн бодит чадавхид тохирсон байх шаардлагатай гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс эдийн засагт тулгамдаад буй асуудлууд, тэдгээрийн ач холбогдлын түвшин болон хүн амын үзүүлэлтүүдийг хооронд нь уялдуулсан ямар бодлогууд хэрэгжүүлж болох талаар цөөн хэдэн саналыг тодорхой тоо мэдээн дээр тулгуурлан гаргалаа.

Өнөөдөр манай улсын гадаад өрийн хэмжээ ДНБ-ний 80 орчим хувьтай тэнцэж байгаа бөгөөд 2008 оноос зээлийн өрийн төлбөрөө төлж эхэлснээр Засгийн газар төдийгүй ядуу эдийн засгийн бусад секторуудад ч хүнд дарамт үзүүлэх болно. Миний бодлоор хүн ам зүйн цонх нээгдсэн өнөөгийн нөхцөл байдлыг бүрэн ашигласнаар энэ хүнд байдлыг тойрон гарах боломжтой гэж бодож байна. Хамгийн гол нь бид хүний нөөц, орлогын эх үүсвэрүүдээ бүрэн гүйцэд оновчтой ашиглах нь чухал. Өнөөгийн байдлаар 15-64 наасны ажил эрхлээгүй хүн амын бараг 40 хувь нь ажил хайгаад олдохгүй байгаа талаар ярьж байгаа нь тун харамсалтай.


Хэрэгжүүлэх ажлын эхэнд банк санхүүгийн салбарт өөрчлөлт шинэчлэлтийг хийх хэрэгтэй гэж үзэж байна. Энэхүү шинэчлэлт нь банкны салбарын бүтэц, үүргийг өөрчлөхтэй холбоогүй, зөвхөн зээлийн бодлогын өөрчлөлтийн талаар ярьж буй хэрэг юм.

Арилжааны банкуудын зээлийн жилийн дундаж хүүгийн түвшин 1998 онд 45.8 хувь, 1999 онд 49.9-38.8 хувь, 2000 онд 45.0-32.2 хувь, 2001 онд 33.9-41.4 хувь, 2002 онд 39-33.4 хувь байсан нь хөгжингүй орууудын жилийн 1-4 хувийн зээлийн хүүтэй харьцуулахад хэт өндөр байна. Ийм зээлийн орчинд жилийн 50 хувийн ашигтай ажилладаг бизнес хүртэл дампууралд хүрч болзошгүй юм.

Зээлийн хүүгийн түвшнээс гадна зээлийн хугацаанд анхаарах нь зүйтэй. Аливаа бизнес стратегийн зорилтууддаа хүрэхэд дор хаяж 3-5 жил шаардагддаг бол өнөөдрийн манай банкуудын олгож байгаа зээлийн хамгийн урт хугацаатай нь л 2 жил байгаа учир бизнесийн өсөлтийг дэмжих чадваргүй гэж дүгнэж болохоор байна. Мөн зээлийн шинэ төрлүүдийг бий болгох зайлшгүй хэрэгцээ ажиглагдаж байна. Хэрэв манайд хэрэглээний зээлүүдийг өргөнөөр олгодог бол хүмүүсийн худалдан авах чадварт ахиц гарч эрэлтийн өсөлт бий болох боломжтой. Мэдээж эрэлтийн өсөлтийг дагаад нийлүүлэлт буюу үйлдвэрлэлийн хэмжээ өсөх болно. Өөрөөр хэлбэл худалдан авах чадварын өсөлт эдийн засгийн өсөлтийг бий болгодог тухай өмнө ярьснаа дахин давтсан хэрэг юм.

Хэт өндөр хүүгийн түвшин нь улсын дотоод эх үүсвэрээс хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд сөргөөр нөлөөлж байгаа нь 1997-2000 оны хооронд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 4-8 хувь нь банкны зээлээр санхүүжигдсэн гэсэн статистикаар батлагдаж байгаа юм.

Зураг 7. Хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэрээр, 1997-2002



Гадаад эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын талаас илүү хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гадаад эх үүсвэрүүд дотроо зээл, тусlamж 70-80 хувьтай, гадаадын шууд хөрөнгө оруулалт 20-30 хувьтай байгаа нь үйлдвэрлэлийн өсөлтийг бий болгох чадвар сүл байна. Учир нь гадаадын зээл тусlamжууд бодит үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэсээ илүү засгийн газрын үйл ажиллагааг дэмжсэн байдаг. Эндээс эдийн засгийн өсөлтийг хангах үр ашигтай хөрөнгө оруулалтыг бий болгох хэрэгтэй гэсэн дүгнэлт гарч байна. Эдийн засгийн өсөлт авчрах, үр ашигтай хөрөнгө оруулалтын нэг хэлбэрт үнэт цаасны хөрөнгө оруулалт тооцогддог хэдий ч үүнийг хэрэгжүүлэх гэсэн манай оролдлогууд бүтэлгүйтсэн билээ.

20-р зууны 2-р хагаст мэдээллийн технологийн дэвшил олон орны хөгжлийн гол түлхүүр болсон гэдгийг бид мэднэ. Мэдээллийн технологи нь газарзүйн байршилаас үл хамааран мэдээлэл солилцох, бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах боломжуудыг агуулж байдгаараа Монгол шиг өргөн уудам нутагтай (дэд бүтэц сүл хөгжсөн), хүн ам цөөн жижиг улсын хувьд онцгой ач холбогдолтой зүйл билээ. Энэ давуу талыг нь ашиглаж улсаа хөгжүүлэх боломжийг хайж олох л хэрэгтэй. Тухайлбал, дэлхийн үнэт цаасны зах зээл дээрээс Монголын уул уурхай, аж үйлдвэрийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг олох ажилд мэдээллийн технологийг голлох үүрэгтэйгээр ашиглаж болох юм.

Манай улсын эдийн засгийн өсөлтөд өгөөжтэй өөр нэг хүчин зүйл бол олон улсын эдийн засгийн харилцааны либеральчлал юм. Олон улсын эдийн засгийн харилцаа ардчилсан хэв маягтай болсноор улс орнуудын экспорт нэмэгдэж, хөдөлмөр, капитал гэсэн үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдийн шилжилт чөлөөтэй болж эдийн засгийн өсөлтөд нь эерэг нөлөө үзүүлэх болжээ. Тиймээс бүх орнууд өөрсдийн эдийн засгаа нээлттэй байлгахыг чармайж эдийн засгийн хамтын нийгэмлэг хэлбэрээр ажиллаж байна. Өнөөгийн байдлаар Азийн орнуудаас Монгол л ганцаараа эдийн засгийн ямар нэгэн интеграцичлалд ороогүй байна.

Орчин үеийн глобальчлал, интегральчлалын нөлөөгөөр улс орнуудын хооронд хөдөлмөрийн нөөц харьцангуй чөлөөтэй шилждэг болсон. Манай улсын хувьд дотооддоо ажлын байраар хангаж чадахгүй байгаа хөдөлмөрийн нөөцийн тодорхой хэсгээ хөдөлмөрийн хөлс өндөртэй хөгжингүй орнууд руу илгээж болно. Гэхдээ засгийн газар иргэдийнхээ эрх ашигийг НҮБ-ын конвенциуд болон 2 талын гэрээ хэлэлцээрүүдээр баталгаажуулж байх ёстой. Хөдөлмөрийн нөөцийн илүүдэл хэсгээ гадагш нь экспортлоно гэдэг нь хүний нөөцөө ашиглаж

байгаагийн нэг илрэл бөгөөд шилжигчдийн ар гэрийнхний амьжиргаанд ч мөн сайнаар нөлөөлнө. Түүнчлэн хилийн чанадад ажиллаж байгаад Монголдоо буцан ирж буй хүмүүс тухайн орныхоо ашигтай туршилагуудыг нутагтаа дэлгэрүүлэх болно. Ингэснээр технологийн дэвшил гарч, үйлдвэрийн нөөцийн үр ашигтай ашиглалт сайжирдаг гэдэг нь Япон, БНСУ гэх мэт Зүүн Хойд Азийн орнуудын туршилагаар нотлогддог.

Эдийн засгийн салбарууд дотроос хөдөлмөрийн насын хүн амын тал хувь, ДНБ-ний 1/3-тэй холбогддог учир хөдөө аж ахуйн салбар, ялангуяа мал аж ахуйн салбарын хөгжил олон нийтийн анхаарлын төвд оршдог. Тиймээс бид бүгдээрээ энэ салбарыг хөгжүүлэхтэй холбоотой малын үүлдэр угсааг сайжруулах, аж ахуйн зохион байгуулалтын шинэлэг хэлбэр бүрдүүлэх гэх мэтийн санал, санаачлагыг дэмжих нь зүйтэй байна.

## Дүгнэлт

Сүүлийн арваад жилийн төрөлтийн бууралттай холбоотойгоор хөдөлмөрийн насын хүн амд ногдох тэжээгдэгч хэсгийн тоо буурч байгаа нь хүн амын хэтийн тооцооны үр дүнгээс харагдсан бөгөөд энэ нь эдийн засгийн утгаараа «хүн ам зүйн цонх» нээгдэж буй хэрэг юм. Хүн ам зүйн цонх нь эдийн засгийн өсөлтөд зөрэгээр нөлөөлөөд зогсохгүй, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гол зорилтууд болох хүний хөгжил, ядуурлын бууралтад дэмжлэг үзүүлдгээрээ амин чухал ач холбогдолтойд тооцогддог. Манай улсын хүн ам зүйн цонх дараах хэдэн үндсэн шинжийг агуулж байна.

1. 1980-аад оны сүүл, 90-ээд оны эхээр тохиосон ардчилсан хувьсгалын нөлөөгөөр хүн ам зүйн шилжилтийн 3-р үе эхэлж нийт хүн амд хөдөлмөрийн насынхны эзлэх хувь өссөн. Хөдөлмөрийн насын хүн амын хувийн жин өссөнөөр эдийн засгийн өсөлтөд ямар нэгэн эерэг нөлөө үзүүлэх болно.
2. Тэжээгдэгч хэсгийн бүтцийг харахад хүүхдүүдийн хувийн жин хөгшчүүдийнхээс өндөр байна. Хэдийгээр төрөлтийн түвшин буурч байгаа боловч «төрөлтийн тэсрэлт»-ийн үсийн төрөлтүүд нөхөн үржихүйн насандаа хүрсэнтэй холбоотойгоор хүүхдүүдийн өсөлт тогтмол байна. 65-аас дээш насын хөгшчүүдийн хувьд 1930-аад оны хэлмэгдүүлэлт, 1940-өөд оны эх орны ба дэлхийн дайн болж байсантай холбоотойгоор төрөлтийн хүлээлт үүсээд байсан үед төрсөн учир тооны хувьд цөөн байдал. Гэвч хүн амын өсөлтийн чиг хандлагаас харахад «төрөлтийн тэсрэлт»-ийн үсийнхэн ахмад насандаа хүрч тэжээгдэгчдийн хувийн жин нэмэгдсэнээр тэтгэвэр тэтгэмжийн сан болон эрүүл мэндийн үйлчилгээний зардал өсөх төлөвтэй байна.
3. Бүс нутгуудын хөдөлмөрийн насын хүн амын тодорхой хэсэг нь дотоод шилжих хөдөлгөөний төв болох Улаанбаатар хот руу шилжиж байгаа учир Улаанбаатар хотод хүн ам зүйн ачаалал хамгийн бага байна.
4. Хөдөлмөрийн насын хүн амын 46.5 хувь нь ажил эрхлээгүй учир хүүхэд, хөгшдийн нэгэн адил нөгөө хэсгийнхээ нуруун дээр ачаалал бий болгож байна. Харин тэдний 38.1 хувь нь ажиллах хүсэл сонирхолтой байгаагаараа ашиглах боломжтой нөөцөд тооцогдож байна.

Эцэст нь хэлэхэд, Монголын эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх хүн ам зүйн таатай боломж 2030-аад оны дунд үеэр төгсгөл болох төлөвтэй тул өмнө дурдсан арга замуудаар эсвэл өөр шинэ аргуудыг олж хүний нөөцийн ашиглалтын чиглэлээр эдийн засгийн хүчтэй бодлого явуулах зайлшигүй

шаардлагатайг Монгол орны хувь заятай холбоотой шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад анхааруулмаар байна.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. МБ, 2002. Монгол банкны жилийн эмхтгэл, Монгол банк, Улаанбаатар, Монгол
2. ҮСГ, 2001. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн. Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, Монгол
3. ҮСГ, 2002. Хүн амын хэтийн тооцооны монограф, Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, Монгол
4. ҮСГ, 2003. Монгол Улсын хүн ам XX зуунд эмхтгэл, Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, Монгол
5. [www.census.gov](http://www.census.gov)